

ЛИЦЕНЗИЙН ГЭРЭЭ БОЛОН ОЮУНЫ ӨМЧИЙН АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ БУСАД ГЭРЭЭГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Лицензийн гэрээ, оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэх журмын (цаашид “Журам” гэх) зорилго нь оюуны өмчийн эрхийн лицензийн гэрээ болон ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, нийтэд мэдээлэх болон гэрээний бүртгэл хөтлөхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн лицензийн гэрээг албан журмаар бүртгэнэ, харин оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээ, зохиогчийн эрхийн бүтээл болон түүнд хамаарах эрхэд хамаарах ашиглалттай холбоотой гэрээг тус тус сайн дурын хүсэлтийг үндэслэн бүртгэнэ.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсанаар ойлгоно.

1.3.1. “Лицензийн гэрээ” гэж Патентын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т нэр заасан лицензийн гэрээг;

1.3.2. “Оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээ” гэж Журмын 1.3.1 - д заасан нэрлэсэн гэрээнээс бусад буюу оюуны өмчийг ашиглахтай холбоотой нөхцөл бүхий гэрээг;

1.3.3. “Гэрээний албан журмын бүртгэл” гэж Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн лицензийн гэрээг Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд зааснаар бүртгэх үйл ажиллагааг;

1.3.4. “Гэрээний сайн дурын бүртгэл” гэж хуульд албан журмаар бүртгүүлэхийг шаардсанаас бусад, оюуны өмчийн ашиглалттай холбоотой аливаа гэрээг эзэмшигчийн сайн дурын хүсэлтийг үндэслэн албан журмын бус бүртгэлийн үйл ажиллагааг;

- 1.3.5. “Гэрээний бүртгэлийн мэдээллийн сан” гэж хууль болон Журамд заасан нөхцөлийн дагуу бүртгэлд бүртгэсэн лицензийн гэрээ болон оюуны өмчийн ашиглалттай холбоотой гэрээний бүртгэлийн цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг;
- 1.3.6. “Нийтэд мэдээллэх” гэж гэрээ байгуулагдсан тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллага албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлэхийг

Хоёр. Лицензийн гэрээг бүртгүүлэх тухай хүсэлт

2.1. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Патентийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т тус тус заасан лицензийн гэрээг бүртгүүлэх тухай хүсэлтийг эрх эзэмшигч (цаашид “лиценз өгөгч” гэх), лиценз авагч эсхүл эдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн аль нэг нь Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-1, Маягт Л-2 ын дагуу гаргана.

2.2. Хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

2.2.1.Лиценз өгөгчийн нэр, хаяг

2.2.2.Лиценз өгөгч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг

2.2.3.Лиценз авагчийн нэр, хаяг

2.2.4.Лиценз авагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг

2.2.5.Лицензийн зүйл болох шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн улсын бүртгэлийн дугаар эсхүл дугаарууд

2.2.6.Лицензийн хамрах хүрээ

2.2.7.Лицензийн төрлийн заалт

2.2.8.Лицензийн хугацаа (зөвшөөрлийн хугацаа эхлэх болон дуусгавар болох огноо)

2.3. Хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана:

2.3.1.Лиценз нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт хамаарч байвал эх гэрээ эсхүл лицензийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,

2.3.2.Лиценз нь барааны тэмдэгт хамаарч байвал Лицензийн гэрээний талууд болон лицензээр олгосон эрхийг заасан холбогдох хэсгийн хуулбар. Ингэхдээ хуулбар нь эх гэрээний хэсгийн хуулбар мөн болохыг нотариат эсхүл эрх бүхий бусад

байгууллагаар гэрчлүүлсэн байх, эсхүл Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-3-ын дагуу лиценз өгөгч ба лиценз авагч нарын гарын үсэг зурж баталгаажуулсан мэдэгдэл,

2.3.3.Лиценз нь Дэд лиценз бол лицензийн Үндсэн гэрээ,

2.3.4.Журмын энэ зүйлийн 2.3.1, 2.3.2-т заасан зүйлүүд нь Монгол хэлнээс өөр хэлээр үйлдэгдсэн бол түүний орчуулга,

2.3.5.Лиценз өгөгч болон лиценз авагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол итгэмжлэл,

2.3.6.Лицензийн гэрээний тал болоогүй хамтран эзэмшигч бүр лицензийн гэрээг зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан мэдэгдэл,

2.3.7.Тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлс төлсөн баримт

Гурав. Оюуны өмчийн ашиглалттай холбоотой гэрээг бүртгүүлэх тухай хүсэлт

3.1. Аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой гэрээг бүртгүүлэх тухай хүсэлтийг эрх эзэмшигч, эрх хүлээн авагч эсхүл эдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн аль нэг нь Журмын хавсралтаар батлагдсан Маягт Г-1-ийн дагуу хүсэлтээ сайн дураар гаргана.

3.2. Хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана.

3.2.1. Эх гэрээ эсхүл гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,

3.2.2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол итгэмжлэл,

3.2.3. Үйлчилгээний хөлс төлсөн баримт

Дөрөв. Лицензийн гэрээ болон Оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэх

4.1. Хүсэлтийг бүртгэлийн мэргэжилтэн хүлээн авч, энэ тухай мэдэгдлийг үйлдэж, хүсэлт гаргагчид гардуулан өгнө.

4.2.Бүртгэлийн мэргэжилтэн хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор түүний бүрдлийг хянана.

4.3.Бүртгэлийн мэргэжилтэн бүрдэл хангагдсан хүсэлтийг цахимжуулж, лицензийн гэрээг бүртгэсэн тухай мэдэгдлийг Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-4, Маягт Л-5-ын дагуу, аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэсэн тухай мэдэгдлийг Журмын хавсралтаар батлагдсан Маягт Г-2-ын дагуу тус

тус үйлдэж, нэгжийн даргад хянуулан хүсэлт гаргагчид бичгээр эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ.

4.4.Бүрдэл хангагдаагүй бол зохих засварыг ажлын 20 хоногийн дотор хийж ирүүлэхийг хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

4.5.Хүсэлт гаргагч мэдэгдлийг хүлээж авснаас хойш журмын энэ зүйлийн 2.5.4-д заасан хугацаанд засварыг хийж ирүүлээгүй бол лицензийн гэрээ болон аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэхээс татгалзсан тухай мэдэгдлийг энэ журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу үйлдэж хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

Тав. Нэмэлт лиценз болон аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээнд орсон өөрчлөлтийг бүртгэх, гэрээг цуцлах

5.1.Нэмэлт лиценз бүртгүүлэх тухай хүсэлтийг Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-6, Маягт Л-7 маягтын дагуу гаргаж, дараах зүйлийг хавсаргана

5.1.1.Нэмэлт лицензийг нотлох баримт бичиг,

5.1.2.Нэмэлт лиценз нь барааны тэмдэгт хамаарч байвал Лицензийн гэрээний талууд болон лицензээр олгосон эрхийг заасан холбогдох хэсгийн хуулбар. Ингэхдээ хуулбар нь эх гэрээний хэсгийн хуулбар мөн болохыг нотариат эсхүл эрх бүхий бусад байгууллагаар гэрчлүүлсэн байх, эсхүл Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-3-ын дагуу лиценз өгөгч ба лиценз авагч нарын гарын үсэг зурж баталгаажуулсан мэдэгдэл,

5.1.3. Лиценз өгөгч болон лиценз авагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол итгэмжлэх бичиг

5.1.4. Журмын энэ зүйлийн 5.3.1-д заасан зүйл нь Монгол хэлнээс өөр хэлээр үйлдэгдсэн бол түүний орчуулга.

5.2.Аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээнд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг нотлох баримт бичгийн хамт бичгээр гаргана.

5.3.Нэмэлт лиценз болон аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээнд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг улсын бүртгэлийн мэргэжилтэн хүлээн авч, бүрдлийг хянаж, улсын бүртгэлд тэмдэглэл хийж хүсэлт гаргагчид энэ тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

5.4. Лиценз цуцлах тухай хүсэлтийг Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-8, Маягт-Л 9-ийн дагуу гаргаж, дараах зүйлийг хавсаргана.

5.4.1. Лиценз цуцалсан тухай нотлох баримт бичиг, эсхүл

5.4.2. Лиценз цуцалсан тухай хүсэлт нь барааны тэмдэгт хамаарч байвал Журмын хавсралтаар батлагдсан Маягт Л-3-ын дагуу лиценз өгөгч ба лиценз авагч нарын гарын үсэг зурж баталгаажуулсан мэдэгдэл,

5.4.3. Лиценз өгөгч болон лиценз авагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол итгэмжлэх бичиг

5.5. Аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг цуцлах тухай хүсэлтийг нотлох баримт бичгийн хамт бичгээр гаргана.

5.6. Хүсэлтийг бүртгэлийн мэргэжилтэн хүлээн авч, бүрдлийг хянаж, лицензийн гэрээ болон аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээний бүртгэлд тэмдэглэл хийж, хүсэлт гаргагчид энэ тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

Зургаа. Зохиогчийн эрхийн бүтээл болон түүнд хамаарах эрхийн объектын гэрээг сайн дураар бүртгүүлэх болон бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт

6.1. Зохиогчийн эрхийн бүтээл болон түүнд хамаарах эрхийн объектын лиценз буюу ашиглалттай холбоотой гэрээг бүртгүүлэх хүсэлтийг зохиогч, гүйцэтгэгч уран бүтээлч эсхүл ашиглах онцгой эрх эзэмшигч Журмын хавсралтаар баталсан Маягт Г-3-ын дагуу хүсэлтээ сайн дураар гарган бүртгүүлж болно;

6.2. Хүсэлт гаргагч нь тухайн гэрээг бүртгүүлэх хүсэлт гаргах эрх бүхий этгээд бөгөөд бусдын хууль ёсны эрх, ашиг сохирхлыг хөндөөгүй гэдгийг шаардлагатай тохиолдолд нотлох үүрэгтэй;

6.3. Зохиогчийн эрхийн бүтээл болон түүнд хамаарах эрхийн объектын лиценз буюу ашиглалттай ашиглалттай холбоотой гэрээний сайн дурын бүртгэл нь ямар нэгэн баталгаа болохгүй мөн хууль зүйн үр дагавар үүсгэхгүй.

6.4. Хүсэлт болон гэрээний бодит үнэн болон хууль тогтоомжид заасан шаардлага хангасан эсэхийг хүсэлт гаргагч бүрэн хариуцна;

6.5. Хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

6.5.1. Бүтээлийн эрх эзэмшигчийн нэр, хаяг

6.5.2. Бүтээлийн эрх эзэмшигч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг

6.5.3. Эрх хүлээн авагчийн нэр, хаяг

6.5.4. Эрх хүлээн авагчийн нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг

6.5.5. Хамрах хүрээ

6.5.6.Гэрээний төрлийн заалт

6.5.7.Гэрээний хугацаа (зөвшөөрлийн эхлэх болон дуусгавар болох огноо)

6.6. Хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана:

6.6.1.Гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,

6.6.2.Хэрэв гэрээ нь Монгол хэлнээс өөр хэлээр үйлдэгдсэн бол түүний орчуулга,

6.6.3.Бүтээлийн эрх эзэмшигч болон эрх хүлээн авагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол итгэмжлэл,

6.6.4.Нэгээс дээш эрх эзэмшигчтэй бүтээл, хамаарах эрхийн объектын хувьд гэрээний тал болоогүй хамтран эрх эзэмшигч бүр гэрээг зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан мэдэгдэл,

6.6.5.Тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хураамж төлсөн баримт.

6.7. Гэрээний бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг бичгээр гаргана.

6.8. Гэрээний бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтэд шаардлагатай тохиолдолд энэ Журмын 6.6-д заасан баримт бичгийг хавсаргана.

6.9.Хүсэлтийг улсын бүртгэлийн мэргэжилтэн хүлээн авч, бүрдлийг хянаж, гэрээний бүртгэлд тэмдэглэл хийж, хүсэлт гаргагчид энэ тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

6.10.Гэрээний бүртгэлийг цуцлах тухай хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана.

6.10.1.Гэрээ цуцалсан тухай хүсэлтийг нотлох баримт бичиг

6.10.2.Бүтээлийн эрх эзэмшигч болон эрх хүлээн авагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол итгэмжлэл

6.11.Хүсэлтийг бүртгэлийн мэргэжилтэн хүлээн авч, бүрдлийг хянаж, гэрээний бүртгэлд тэмдэглэл хийж, хүсэлт гаргагчид энэ тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

6.12.Эрх хүлээн авагч нь Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх зөрчсөн талаарх гомдол, хүсэлт, нэхэмжлэл гаргах тохиолдолд бүтээлийн эрх эзэмшигчээс бичгэн зөвшөөрөл авсан байна.

Долоо. Бусад

7.1. Төрийн захиргааны байгууллага нь лиценз бүртгэсэн тухай албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

7.2. Төрийн захиргааны байгууллагад лицензийн гэрээ, оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгүүлээгүй нь тухайн гэрээний зүйл болох оюуны өмчийн эрхийн хүчин төгөлдөр байдал эсхүл эрхийн хамгаалалтад нөлөөлөхгүй.

7.3. Оюуны өмчийн онцгой эрхийг бусдад шилжүүлэх нь Журмын дагуу бүртгэгдсэн лицензийн гэрээ болон аж үйлдвэрийн өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

---- *** ----